



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар A/429

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын
120 дугаар сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 16,121,700 (арван зургаан сая нэг зуун хорин нэгэн мянга долоон зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан эд хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 120 дугаар сургууль (Ю.Базарханд)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 4 нэр төрлийн 2,373,900 (хоёр сая гурван зуун далан гурван мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 7 нэр төрлийн 13,747,800 (арван гурван сая долоон зуун дөчин долоон мянга найман зуу) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 35,000 (гучин таван мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь 10,500 (арван мянга таван зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 120 дугаар сургууль (Ю.Базарханд)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001165



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 11 дугаар сарын 24-ны өдрийн өдрийн... дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 120 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨАУГ-ын мэргэжилтний үнийн санал	ЭБХХК-ын хурлын шийдвэр
1	Проектор Benq	8	ш	2	770,000.0	1,540,000.0	1,540,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
2	Махны машин	8	ш	1	520,000.0	520,000.0	520,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
3	Хөлдөөгч	8	ш	1	350,000.0	350,000.0	350,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
4	Будаа агшаагч	8	ш	1	192,000.0	192,000.0	192,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
5	CD I-Pod FM USB Тоглуулагчтай хөгжим PHILIPS	8	ш	1	352,000.0	352,000.0	352,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
6	Sony dsc зургийн аппарат	8	ш	1	289,900.0	289,900.0	289,900.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
7	Өнгөт принтер Epson TX 129	6	ш	1	299,900.0	299,900.0	299,900.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
8	Өнгөт принтер Epson XP402	6	ш	1	299,900.0	299,900.0	299,900.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
9	Принтер Samsung ML 3310	6	ш	1	179,000.0	179,000.0	179,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
10	Принтер Samsung SC 3400	6	ш	1	199,000.0	199,000.0	199,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
11	Суурин Компьютер	8	ш	20	595,000.0	11,900,000.0	11,900,000.0	-	ашиглах боломжгүй	актлах	актлах	устгах	устгах
Тоног төхөөрөмжийн дүн													
						16,121,700.0	16,121,700.0					35,000.0	35,000.0
Үүнээс Худалдах хөрөнгө						13,747,800.0							
Актлах хөрөнгө						2,373,900.0							
Татан төвлөрүүлэх хөрөнгө													
Худалдсанаас олох орлого						35,000.0							
НӨХГ-т төвлөрүүлэх 30%						10,500.0							